

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.03.24 №15 (15)

ҮЙЛ ЯВДАЛ

ОНЛАЙН ШАТРЫН АВАРГУУД ТОДРОВ



Батлан хамгаалах яамны 110 жил, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, "Алдар" спорт хороо үүсэн байгуулагдсаны 75 жилийн ойн нэрэмжит шатрын цахим тэмцээнийг 3 дугаар сарын 20-ны өдөр LICHESS.ORG цахим флатформ дээр зохион байгууллаа.

Тэмцээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги, байгууллагуудаас нийт 22 тамирчин оролцож түргэн тоглолтоор 11 өрөг тоглож оюун ухаанаа сорьсноос эрэгтэйчүүдээс бэлтгэл дэд хурандаа Б.Дүүрэнбаяр /Зэвсэгт хүчний 120 дугаар анги/,

032 дугаар ангийн дэд түрүүч Б.Баасансүрэн, ҮБХИС-ийн оюутан Б.Сэржбүдээ нар эхний 3 байрыг эзэлж шагналт байранд 123 дугаар ангийн ахмад Д.Тамир, 032 дугаар ангийн байлдагч Б.Тунамал нар шалгарав. Эмэгтэйчүүдээс Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн Б.Гүнцэцэг, мөн ангийн ахлагч Ц.Оюунчимэг нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын цомоор шагнагдлаа.

Шагналыг Батлан хамгаалах яамны харьяа, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны дарга, хурандаа Г.Өсөхбаяр гардуулж, баяр хүргэлээ.

ХИЛИЙН ЧАНАДААС

"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ӨӨР "НАТО"-ИЙН МЕДАЛИА ГАРДАН АВЛАА



ИБНАУ-д явагдаж буй "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын XII ээлжийн бие бүрэлдэхүүн "Нато"-ийн медиалаа гардан авах ёслолын ажиллагаа боллоо. Тус ажиллагаанд "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагааны хүчний командлагч, генерал Аустин Скотт Миллер оролцсон бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ "Би АНУ-ын Зэвсэгт хүчинд алба хаах хугацаандаа олон ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бөгөөд анх удаа Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчидтай хамт үүрэг гүйцэтгэж байна. Монгол цэрэг тавигдсан үүргийг сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд мэргэжлийн ур чадвартайгаар гүйцэтгэдэг. Тийм учраас Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтэд эргэлзэхгүй байгаагаар онцлон тэмдэглэмээр байна. Өнөөдөр Монгол Улсын Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баяр, "Монгол цэргийн өдөр"-өөр танай цэргийн багийн бүрэлдэхүүнтэй уулзах завшаан тохиолдсонд би баяртай байна. Та бүхэнд "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баяр"-ын мэндийг хүргэе" гэсэн юм.

Тэрээр өөрийн нэрэмжит шагналаар хошууч Х.Ууганбаатар,

дэслэгч Т.Мөнхболд, ахлагч Э.Цэдвээ, дэд ахлагч Б.Бат-Эрдэнэ нарын 11 цэргийн алба хаагчийг шагнаж, дурсгалын медалион хадгалуулсан юм.

Мөн Кабулын аюулгүй байдлыг хангах хүчний командлагч, бригадын генерал Олли Браун Шинэ Кабул Баазын аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, мэргэжлийн ур чадварт эргэлзэхгүй байна. Та бүхний явуулж байгаа цэргийн сургалт бэлтгэл бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байгааг олон удаа харлаа. Та бүхний үүрэг гүйцэтгэж байхад эвслийн цэргийн хүчний бүрэлдэхүүн тайван амарч байдаг. Өнөөдөр та бүхэнд "Умард Атлантын Гэрээний Байгууллага"-ын медалийг гардуулан өгч байгаадаа баяртай байна. Энэ бол та бүхний ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж эхэлснээс өнөөдрийг хүртэл хийсэн зүйлийн тань үнэлэмж бөгөөд цаашид албаа нэр төртэй хаах урамшуулал юм" гээд баярын мэнд хүргэлээ.

Баярын арга хэмжээний хүрээнд АНУ-ын генерал Аустин Скотт Миллер, ахмад Жесика Миллер, сургагч ахлагч Жуан Рестрепо болон АНУ-ын офицер, ахлагч, ажилчдад цэргийн багийн удирдлага дурсгалын зүйл гардуулж, хүндэтгэл үзүүлэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 9°C	☁️ -4°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 41°C	☁️ 28°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 15°C	☁️ 2°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.0	2,858.0
EUR 🇪🇺	3,363.0	3,428.0
CNY 🇨🇳	435.50	439.80
RUB 🇷🇺	37.53	39.26
JPY 🇯🇵	25.90	26.53
KRW 🇰🇷	2.46	2.57

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	206
НИЙТ БҮРТГЭГДСЭН	5392
ЭДГЭРСЭН	3758
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	15
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	243
ЭДГЭРСЭН	1036
НИЙТ БАТЛАГДСАН	1279

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.24
/ЛХАГВА ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН ЦАГААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулвал:
Эрхтэн хурц болно

Наран ургах, шингэх:
06.47-19.10

Барилдлага: Үхэх

Шүтэн барилдлага: Мунхрахуй

Суудал: Отгоргүй

Билгийн тооллын 11, Найралт эх одтой, цагаагчин хонь өдөр. Өдрийн наран 6 цаг 47 минутад мандан, 19 цаг 10 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандаж хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, отгоргүйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдах авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсоод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

ОНОЛ, ПРАКТИКИЙН ХУРАЛ ЦАХИМААР ЯВАГДАВ

ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албанаас 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны хүрээнд "Эрдэм судлал-2021" магистрант, докторантуудын эрдэм шинжилгээний онол, практикийн хурлыг зохион байгуулав.

Цахим хуралд Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор, хурандаа Б.Өлзийхуяг, ахисан түвшний сургалтын албаны дарга, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа Д.Отгонцэцэг, доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав, профессорын багийн ахлагч, доктор (Sc.D), профессор Л.Батцэнгэл, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа Б.Эрдэнэчимэг, доктор (Ph.D), дэд профессор С.Болорцэцэг, доктор (Ph.D), дэд хурандаа Т.Мөнх-Оргил, доктор (Ph.D), дэд профессор, хошууч Г.Пүрэвсүрэн нарын эрдэмтэн, судлаачид оролцов.

Ахисан түвшний хөтөлбөрт суралцагчдаас 50 гаруй илтгэл ирснээс докторант Ц.Буянцогтоо "Энэтхэг-Номхон далайн стратегийн өнөөгийн байдал, цаашдын

хандлага", докторант Н.Соёлгэрэл "Олон улсын харилцаа, бус нутгийн геополитикийн орчны өөрчлөлтөд хийсэн судалгаа, дүн шинжилгээ", Докторант, хошууч Г.Батбаяр "Тактикийн хөгжилд гарч буй өөрчлөлт", докторант, дэслэгч М.Мөнгөнцэцэг "ОХУ-ын Зэвсэгт хүчний материал хангалтын онцлог", магистрант Б.Баярчимэг "Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын сэтгэцийн байдалд нөлөөлж буй зарим асуудал", магистрант, хошууч Ө.Нарантуяа "Цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандаж хандлага, түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйл", магистрант Б.Санчирмаа "Төрийн бодлогын залгамж чанар түүнд хийсэн судалгаа", магистрант Т.Оргилхүү "Геополитикийн өөрчлөлт ба Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөв", магистрант А.Амартайван "Япон Улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлт", магистрант Б.Баттулга "Маршийн аялгуугаар цэргийн алба хаагчдын сэтгэл зүйд нөлөөлөх нь" зэрэг сэдвээр судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлээ.



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГАЗАР ХӨДӨЛӨЛТИЙН ҮЕД ИРГЭН ТА ӨӨРИЙГӨӨ БОЛОН БУСДЫГ ХЭРХЭН АВРАН ХАМГААЛАХ ВЭ?

1. Хүчтэй чичиргээ ихэнхдээ 1 минут орчим үргэлжилдэг тул бат бөх ширээн дор орж, толгойгоо хамгаалах хэрэгтэй. Эсвэл жин, овор ихтэй тавилга болон цонхноос аль болох хол зайтай ханан талд очиж суу.
2. Гудамжинд явж байхад тань газар хөдөлвөл барилгын тоосго, мод, цонхны шил, гэрэлтүүлгийн болон зар сурталчилгааны багана, самбар зэрэг гэмтээж болох зүйлээс хол, нээлттэй, задгай талбай олж зогс.
3. Гадагш гарах гэж яарах хэрэггүй. Орчин тойрныг ажиглаж, тайван байх хэрэгтэй. Цахилгаан шат ашиглахыг хориглоно.
4. Хаалгаа онгойлгох. Хаалган дор зогсоход аюул багатайгаас гадна гадагш гарахад тустай.
5. Цахилгаан болон хийн зуухыг салга. шуугиан үүсдэг тул тайван байж, тухайн байгууллагын ажилтны заавар зөвлөгөөг дага.
6. Дэлгүүр, зах, үзвэр, үйлчилгээний газар олон хүнтэй орчинд хүмүүс сандралд орж үймээн, шуугиан үүсдэг тул тайван байж, тухайн байгууллагын ажилтны заавар зөвлөгөөг дага.
7. Автомашинаар зорчиж яваа тохиолдолд нэн даруй зогс. Нүхэн гарцын дор, өндөр барилгын хажууд зогсож болохгүй.
8. Гамшгийн үед хүмүүс цуу ярианд автах, төөрөлдөх явдал их байдаг тул нутгийн захиргааны болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагаас өгч буй бодит мэдээлэлд анхаарнаа хандуул.

"ААВДАА ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ" УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ШАЛГАРЛАА

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Туурга тусгаар төр улсынхаа сүр хүч, золбоо хийморь нь болсон цэрэг эрсийн баяр, "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтан хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх хэлний гайхамшигийг мэдрүүлж, уран яруу үг хийгээд найруулга зүйн чадварыг дээшлүүлэх, аавыгаа хайрлах, халамжлах сэтгэлийн илэрхийлэл захираг

сурагч Ц.Өсөхбаяр, 124 дүгээр сургуулийн 11а ангийн сурагч Б.Должинсүрэн, 107 дугаар сургуулийн 5д ангийн сурагч Т.Жавхлан нар эхний гурван байрыг эзлэж, тусгай байрт 65 дугаар сургуулийн 116 ангийн сурагч Б.Хилчинцэцэгийн аавууддаа бичсэн захидал шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.



зууцлах зорилгоор "Аавдаа захидал бичих" цахим уралдааныг Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан юм.

"Аавдаа захидал бичээрэй" цахим уралдааны 2 дугаар шатанд 15 сургуулийн 42 сурагчийн захидал тунаж үлдсэнээс Нийслэлийн 12 дугаар сургуулийн 7в ангийн

Мөн "Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан олон арга хэмжээг зохион байгуулсны нэг нь Зэвсэгт хүчний 013 дугаар ангид алба хааж буй дайчдын аав, ах нартаа бичсэн захидлыг Цэргийн штабын даргын мэндчилгээний хамт ар гэрт нь дамжуулж "Монгол цэргийн өдөр"-ийн баярын мэндийг хүргэлээ.

Ахлах дэслэгч Б.БАТЦЭЦЭГ

"МАРШ-ТАКТИК ТУСГАЙ БЭЛТГЭЛ"-ИЙН АВАРГУУД ТОДРОВ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Баянхонгор аймгийн Төрийн цэргийн байгууллагуудын дунд "Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг" шалгаруулах тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй тасаг гэсэн ангилалаар 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн буудлагын талбайд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд аймгийн Төрийн цэргийн байгууллагуудын 12 багийн 112 тамирчид оролцсон бөгөөд тэмцээнийг маршрутын дагуу 10 км-г 6 цэгт зохион байгуулж явуулав. Тус тэмцээнд баг тамирчид идэвх санаачилгатай оролцов.

Мөн түүхтэй ойг тохиолдуулан Баянхонгор аймгийн Цэргийн хүрээний алба хаагчид цэргийн ёслолын жагсаалыг зохион байгууллаа. Цэргийн ёслолын жагсаал Ёслолын жагсаалд Зэвсэгт хүчний анги, салбарууд буюу Зэвсэгт хүчний 339, 325 дугаар ангийн 103 дугаар тусгай салбар, Онцгой

байдлын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчид оролцож яруу алдарт 100 жилийнхээ түүхэн ойн баяраа аймаг орон нутгийн удирдлага, ард иргэдтэйгээ хуваалцлаа.

Тус баярын ёслолын арга хэмжээний үеэр "Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн"-нд тэргүүн байр эзэлсэн баг тамирчдад шагнал гардуулах мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас орон нутагтаа зохион байгуулсан "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" гар зургийн уралдаан, "Цэрэг-Эх орны сэдэвт дууг хэн сайн дуулах вэ" дууны уралдаан, "Эрхийн дээд Монгол эр хүн" эсээ бичлэгийн уралдаан, "Эх орныхоо төлөө зүтгэе" гэрэл зургийн уралдааны тэргүүн байруудыг эзэлсэн иргэдэд шагнал гардуулах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Ахмад Г.БАТ-ӨЛЗИЙ

"ШИЛДЭГ ГАРЫН АВЛАГА" ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Уралдааны зорилго

Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын үйл ажиллагаанд бие бүрэлдэхүүний бүтээлч санал, санаачилга, сэтгэлгээг нэвтрүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслийн ашиглалт, хадгалалт, материал хэрэгслийн хангалтын үйл ажиллагааг дээшлүүлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд оршино.

Хамрах хүрээ

ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын болон ҮБХИС-ийн эрдэмтэн, профессор, багш, офицер, ахлагч, сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, оюутан, ажилтан, алба хаагч.

Тавигдах шаардлага

◆ Зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслийн ашиглалт, хадгалалт, материал хэрэгслийн хангалтын үйл ажиллагаа /эд хэрэгслийг орлогод авах, хангах, хадгалалтыг зохион байгуулах/-г дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, материал, техникийн хангалтын сургалт, бэлтгэлд практик ач холбогдолтой байх;

◆ Гарын авлага нь Монгол Улсын Зэвсэгт хүчинд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, тушаал, заавар, журамд нийцсэн, техник, технологи, тооцооллын үндэслэлтэй байх;

◆ Гарын авлагыг цэргийн алба хаагч ашиглахад хялбар, ойлгомжтой, зураглал бүхий тайлбартай, ажлын үндсэн агуулгыг дэс дараалалд оруулж, загварчилсан байх;

◆ Хэл найруулга, бичиглэлийн алдаагүй, давхардсан санаа, утга агуулагдаагүй, энгийн, үргэлжилсэн биш, ойлгомжтой байх;

◆ Зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслийн агрегат, механизм, эд анги, материал хэрэгслийн хангалтын үйл ажиллагааны нэршилд мэргэжлийн хэвшсэн үг хэллэг ашиглах;

◆ Зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслийн бүтэц зохион байгуулалт, эд анги ашиглалт, материал хэрэгслийн хангалтын үйл ажиллагааны зэрэг эх сурвалж, ном, ашиглалтын болон үйл ажиллагааны гарын авлагыг хуулбарлаагүй, үндсэн эх сурвалж, ном, бусад материалуудтай утга, агуулгын зөрчилгүй байх;

◆ Эшлэл татаж ашиглах, эшлэл татсан хэсгийг тэмдэглэж, ашигласан ном, эх сурвалжийн хэсэгт тодорхой тэмдэглэх;

◆ Гарын авлагад нэг сэдвийн хүрээнд цогц байдлаар буюу ерөнхий бүтэц, зохион байгуулалт, ашиглалт, хадгалалт болон материал хэрэгслийн хангалтын үйл ажиллагааны асуудлыг бүхлээр нь тусгасан байх;

◆ Оршил, сэдвийн гарчиг, дэд гарчгууд нь агуулга, бүтэц зөв илэрхийлсэн байх;

◆ Гарын авлагад хэрэглэгдэх код, нэр, томъёо, товчлол нь тайлбартай, хэрэглээ нь хялбар байх;

◆ Гарын авлага нь Монгол Улсын оюуны өмч, зохиогчийн эрх эзэмшигчийн бүртгэлгүй байх,

◆ Гарын авлага нь Агай үсгийн фонд ашиглан, үсгийн хэмжээ 12, мөр хооронд 1.15 мм, А4 хэмжээтэй цаасан дээр, дээрээс 20 мм, баруун гар тал болон доороос 15 мм, зүүн гар талаас 30 мм хэмжээний зайтай, 5-40 хуудас бүхий /80 нүүрнээс илүүгүй/ байна.

Зохион байгуулагч

ЗХЖШ-ын Материал, техникийн газар.

Зохион байгуулалт

Оролцогчид бүтээлээ Материал, техникийн газарт "Шилдэг гарын авлага" шалгаруулах ажлын хэсэгт ирүүлнэ. Бүтээлийг ажлын хэсэг шалгаруулж, байр эзлүүлнэ.

Уралдаанд хувь хүн болон баг оролцож болно.

ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, ҮБХИС-иас ирүүлэх гарын авлагын тоог хязгаарлахгүй.

Бүтээлийг хүлээн авах, шалгаруулах

Оролцогчдын бүтээлийг ЗХЖШ-ын Материал, техникийн газарт "Шилдэг гарын авлага шалгаруулах" ажлын хэсэгт гэж хаяглан шуудангаар болон биеэр хүргүүлнэ. Бүтээлийг 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 17.00 цаг хүртэлх хугацаанд бүтээлийн танилцуулгын хамт хүлээн авна.

Ажлын хэсэг уралдаанд оролцогчдын ирүүлсэн гарын авлага тус бүрийг 2021 оны 9 дүгээр сарын 19-24-ний өдрийн хугацаанд судлан, хурлаар хэлэлцэж, шилдэг 3 бүтээлийг шалгаруулж, оролцогчдод мэдэгдэнэ.

Бүтээлийн танилцуулга

Бүтээлийн танилцуулгын эхэнд оролцогчийн мэдүүлэг байна. Мэдүүлэгт алба хааж байгаа Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын дугаар, албан тушаал, холбоо барих утсыг тодорхой тусгасан байна.

Бүтээлийн танилцуулгын дараагийн хэсэгт гарын авлагын сэдэв, ач холбогдол, үр дүнг тодорхой тусгаж, гарын авлагын бүтэцэд тусгагдсан асуудал бүрийг тодорхой тайлбарлан дүгнэсэн байна.

Гарын авлагын ерөнхий бүтэц

- Нүүр хэсэг
- Оршил
- Нэр, томъёоны тайлал
- Үндсэн хэсэг
- Дэд хэсгүүд
- Дүгнэлт
- Ашигласан ном, эх сурвалж гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Шалгаруулах журам

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн баримтлах шалгуур үзүүлэлтүүдийг 0-100 хүртэл онооны системээр дүгнэж 1,2,3 дугаар байр эзлүүлнэ. Үүнд:

- Хэл найруулга, бичиглэл, утга найруулга /10 оноо/;
- Сэдвийн агуулга, үндсэн хэсэг, дэд хэсгүүдийн агуулга, бүтэц, илэрхийлэл /10 оноо/;
- Гарын авлагыг ашиглахад хялбар, ойлгомжтой, ажлын үндсэн агуулгыг дэс дараалалд оруулж, загварчилсан байдал /20 оноо/;
- Нэг сэдвийн хүрээнд цогц байдлаар асуудлыг тусгасан байдал /20 оноо/;
- Цэргийн алба хаагчийн цэргийн сургалт, бэлтгэлд үзүүлэх ач холбогдол /20 оноо/;
- Гарын авлагад дэвшүүлсэн шинэлэг санаа, бусад тооцоо, өгөгдөхүүн нь материал, техникийн хангалтын үйл ажиллагаанд үзүүлэх ач холбогдол /20 оноо/.

Шагнал

- 1 дүгээр байр – 1, өргөмжлөл, 1,000,000.0 төгрөг
- 2 дугаар байр – 1, өргөмжлөл 800,000.0 төгрөг
- 3 дугаар байр – 1, өргөмжлөл 500,000.0 төгрөг

Ажлын хэсэг "Шилдэг гарын авлага" уралдааны шалгарсан оролцогчдын материалыг 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр шалгаруулна. Цаашид БХЯ, ЗХЖШ-ын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсны дараа оролцогчийн зөвшөөрлөөр цэргийн сургалт, бэлтгэл, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглана.

Холбоо барих хаяг

Баянзүрх дүүрэг, Ажлын хэсэг: Гар утас: 88283581, 80178279, 92090080, 92090076
Энхтайваны өргөн чөлөө 51 Факс: (976-51) 265914
Улаанбаатар хот
Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газар

Оролцогчийн мэдүүлгийн загвар

"Шилдэг гарын авлага" шалгаруулах уралдаанд оролцогчийн мэдүүлэг

Д/д	Оролцогч анги, байгууллагын нэр, дугаар	Оролцогчийн цол, овог, нэр	Албан тушаал	Гарын авлагын сэдэв	Холбоо барих утасны дугаар
1					
2					

ЗХЖШ-ЫН МАТЕРИАЛ, ТЕХНИКИЙН ГАЗАР



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонин редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029